

**НИЙСЛЭЛИЙН ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Нэг. Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүн

1.1. Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт

Монгол Улсын Их хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого"-д заасан 10 стратегийн зорилтыг хэрэгжүүлэн ажиллалаа. Гүйцэтгэл нь тухайн жилийн хүрсэн байх түвшинтэй харьцуулахад 93 хувьтай байна.

Бодлого чиглэл	Заалтын тоо	Зорилтын тоо	Хэрэгжилтийн хувь							Дундаж хувь
			100	90	70	50	30	10	0	
5.1. Макро эдийн засгийн бодлого	2	3		3						
5.2. Эдийн засгийн бодит салбаруудын хөгжлийн бодлого	3	7	5	1	1					
Дүн	5	10	5	4	1					93

1.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагаа"-ны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр тусгагдсан бодлогын 3 чиглэлийн 4 зорилт, арга хэмжээг хяналтад аван хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Бодлого чиглэл	Зорилт, арга хэмжээ	Хувь
Нэг. Ажилтай, орлоготой монгол хүн	Зээлийн батлан даалтын санг үүсгэн байгуулж, дүрмийг батлан үйл ажиллагааг нь эхлүүлнэ.	70
	Барилгын материалын парк, бөөний худалдааны сүлжээг Замын-Үүд, Улаанбаатар хотод байгуулна.	70
2. Ноос, ноолуур, арьс ширний чиглэлээр хэрэгжүүлэх бодлого	Улаанбаатар хотын төвийн дүүргээс арьс шир боловсруулах, ноос, ноолуур угаах үйлдвэрүүдийг нүүлгэх арга хэмжээ авна.	70
7. Үйлчилгээний бизнесийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх бодлого	Улаанбаатар хот орчимд холимог тээврийн ачааны терминал ложистик төв байгуулах ажлыг эхлүүлнэ.	50
Дундаж хувь		65

2015 онд Нийслэлийн төсөвт хөрөнгө оруулалтаар 2,8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тусгаж, Үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн нь эдийн засгийн хүндрэлтэй энэ үед Нийслэлийн зүгээс чухал ач холбогдол өгсөн ажил болсон.

Төр ба хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Улаанбаатар хот орчимд холимог тээврийн ачааны терминал ложистик төв байгуулах ажил нь газрын төлбөрийг хэрхэн барагдуулах асуудлын улмаас хэрэгжилт нь удаашралтай байна. Улаанбаатар хотын ачаа тээврийн нэгдсэн ложистик төв" ХХК-ийн үүсгэн байгуулагчдын хурлыг 2015 оны 05 дугаар сарын 06-ны өдөр хуралдан, газрын дуудлага худалдааны үнийг ложистик төв ашиглалтанд орсноос хойш 5 жилийн дараагаас эхлэн графикайн дагуу 8 жилийн хугацаанд төлж барагдуулах саналыг ирүүлснийг Нийслэлийн зүгээс дахин хэлэлцэхээр тогтоод байна.

1.3. Үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт

Тайлант хугацаанд үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарт үндэсний долоон хөтөлбөр, нийслэлийн таван хөтөлбөр хэрэгжиж байна.

№	Хөтөлбөр, төслийн нэр, батлагдсан огноо, шийдвэрийн дугаар	Хугацаа	Хувь
Нэг. Үйлдвэрлэлийн салбар			
1	Инновацийн тогтолцоог хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, МУ-ын Засгийн газрын 2007 оны 306 дугаар тогтоол	2008-2015	100
2	Монгол улсыг үйлдвэржүүлэх үндэсний хөтөлбөр, МУ-ын Засгийн газрын 2009 оны 299 дүгээр тогтоол	2009-2016	100
3	Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих үндэсний хөтөлбөр, МУ-ын Засгийн газрын 2012 оны 171 дүгээр тогтоол	2013-2016	100
4	Нийслэлийн үйлдвэрлэлийн салбарт инновацийг хөгжүүлэх дэд хөтөлбөр, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011 оны 01 дүгээр тогтоол	2010-2016	100
5	Үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх нийслэлийн хөтөлбөр, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 133 дугаар тогтоол	2015-2025	100
Хоёр. Мал аж ахуйн салбар			
1	Монгол мал үндэсний хөтөлбөр, УИХ-ын 2010 оны 23 дугаар тогтоол	2010-2021	100
2	Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний үндэсний хөтөлбөр, МУ-ын Засгийн газрын 2009 оны 173 дугаар тогтоол	2009-2017	90
3	Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр, МУ-ын Засгийн газрын 2003 оны 160 дугаар тогтоол	2003-2015	100
4	Хоршоог хөгжүүлэх дэд хөтөлбөр, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012 оны 93 дугаар тогтоол	2012-2016	90
5	"Монгол мал" дэд хөтөлбөр, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 119 дүгээр тогтоол	2014-2021	100
Гурав. Газар тариалангийн салбар			
1	"Чацаргана" хөтөлбөр, ЗГ-ын 2010 оны 60 дугаар тогтоол	2010-2016	100
2	Нийслэл хот орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөтөлбөр, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 32 дугаар тогтоол	2014-2020	90

Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.8.1-д "Улаанбаатар хотын сүүний хэрэглээний 80%-ийг дотоодын үйлдвэрлэлээр хангах" зорилтын хүрээнд нийслэлийн онцлогт тохирсон мал аж ахуй эрхлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр "Монгол мал", "Нийслэлийн эрчимжсэн аж ахуйн хөгжлийг дэмжих" дэд хөтөлбөр, бэлчээрийн талбайн хөрсний бүтцийг алдагдуулахгүйгээр өөрийн орны хөрс, цаг уурын нөхцөлд тохируулан, байгаль орчинд ээлтэй, олон наст ногоон тэжээлийг тарималжуулан нутагшуулах замаар тэжээлийн чанарыг сайжруулах зорилгоор "Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих" хөтөлбөрийг боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Нийслэл хотод байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи бүхий экспортын чиглэлийн болон импортыг орлох үйлдвэрлэлийг паркийн хэлбэрээр хөгжүүлэх замаар нийслэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, эдийн засгийн зохистой бүтцийг хангах зорилгоор "Үйлдвэрлэл, технологийн парк хөгжүүлэх" хөтөлбөрийг боловсруулж, батлууллаа.

1.4. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 2015 онд хэрэгжүүлэх 7 үйл ажиллагаанаас 100%-3 ажил, 90%-2 ажил, 70%-1 ажил, 50%-1 ажил дунджаар 85%-тай дүгнэгдсэн.

НЗД бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт		Хувь
НЭГ. АГААР ЦЭВЭР УЛААНБААТАР		
1.2 Хөрс болон орчны бохирдлыг бууруулах чиглэлээр:	1.2.3 Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж буй үйлдвэр, байгууллагыг хотоос гадагш нүүлгэх шат дараалсан арга хэмжээг авна.	90
ГУРАВ. АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ УЛААНБААТАР		
3.5. Багануур дүүргийг хөгжүүлэх чиглэлээр:	3.5.2 “Багануур” үйлдвэр, технологийн паркийн дэд бүтцийг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.	70
3.7. Налайх дүүргийг хөгжүүлэх чиглэлээр:	3.7.1 Орон нутгийн нүүрс, барилгын материалын түүхий эдийн нөөцийг түшиглэн бүх төрлийн барилгын материал, утаагүй түлшний үйлдвэрүүдийг цогцолбороор байгуулна.	90
	3.7.2 Дүүргийн төмөр зам, дэд бүтцийг ашиглан барилгын материалын бөөний худалдаа, ложистикийн төв болгон хөгжүүлнэ.	50
3.8. Эрчимжсэн МАА-н бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр:	3.8.1. Улаанбаатар хотын сүүний хэрэглээний 80%-ийг дотоодын үйлдвэрлэлээр хангана.	100
	3.8.2. Нийслэлийн Сонгино, Бөхөгийн орчмыг гахай, шувуу, загасны аж ахуй эрхлэх бүс болгон хөгжүүлнэ.	100
	3.8.3. Нийслэлийн иргэдийн төмс, хүнсний ногооны хэрэгцээг бүрэн хангана.	100
Дундаж хувь		85

2015 оны улсын хэмжээнд 12,8 мянган га-гаас 165,8 мянган тонн төмс, 6,8 мянган га-гаас 72,9 мянган тонн хүнсний ногоо хураан авч, төмсний хэрэгцээг 100%, хүнсний ногооны хэрэгцээний 47%-ийг хангасан байна. Нийслэл хотын хэмжээнд энэ онд 420 га талбайгаас 4114,5 тонн төмс, 431,17 га талбайгаас 4494,8 тонн хүнсний ногоо, 209,5 га талбайгаас 1612,3 тонн малын тэжээл, 639,7 га-гаа 251,9 тн жимс, жимсгэнэ хураан авсан нь нийслэлийн хүн амын төмсний хэрэгцээний 6,5%, хүнсний ногооны 5%-ийг нийслэлийн иргэд өөрсдөө үйлдвэрлэж байна. 2015 онд манай газраас нийслэлийн иргэдэд газар тариалан эрхлэх мэдлэг олгох 18 сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 600 гаруй иргэдийг хамруулсан.

Хоёр. Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үр дүн

2.1. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт

Тайлант хугацаанд Засгийн газрын гурван тогтоолын 11 заалт, НИТХ-ын долоон тогтоолын 8 заалт, Нийслэлийн Засаг даргын долоон захирамжийн 8 заалтыг хяналтад авч хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа. Хяналтад авсан заалтуудын хэрэгжилтийн дундаж үнэлгээ 91,9 хувьтай байна.

№	Тогтоол, шийдвэрийн		Заалтын тоо	Хэрэгжилтийн хувь						Дундаж хувь	
	Нэр	Тоо		100	90	70	50	30	10		Хугацаа болоогүй
1	Засгийн газрын тогтоол	3	11	7	2	2					
2	НИТХ-ын тогтоол	7	8	5	3	-	-	-	-	-	
3	НЗД-н захирамж	7	8	5	-	2	1	-	-	-	
Дүн											91,9

2.2. Монгол улсын Эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн хэрэгжилт

д/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Хувь
ХОЁР.ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО			
Зорилт 5.Уламжлалт мал аж ахуй, эрчимжсэн мал аж ахуйг дэмжсэн бодлого хэрэгжүүлнэ.			
5.2	ЗГҮАХХАХТ-ний 75.1, 75.2, 75.3, 75.4 дэх заалт	Эрчимжсэн мал аж ахуй, гахай, шувууны аж ахуй эрхэлж байгаа аж ахуйг дэмжих зээлийн санг 50.0 тэрбумаас доошгүй төгрөгийн эх үүсвэртэй байгуулж, үйл ажиллагааг эхлүүлэх	50
5.4	ЗГҮАХХАХТ-ний 69.2, 69.3 дахь заалт	Малын гаралтай түүхий эд, ноолуур, ноос, арьс ширийг дотооддоо боловсруулах	90
Дундаж хувь			70

Нийслэлийн сүүний үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор нийслэлийн төсөвт тусгагдсан 5.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээс сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгч 18 иргэн, аж ахуйн нэгжүүдэд 2 тэрбум 890 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож, 321,2 сая төгрөгийн батлан даалт хийгдсэн байна.

Гахай, шувууны аж ахуй эрхлэгчдийн үйлдвэрлэлээ өргөжүүлэх, шинэчлэх чиглэлээр хэрэгжиж байгаа 1 тэрбум төгрөгийн санхүүжилттэй төслийн хүрээнд 14 иргэн, аж ахуйн нэгж төслөө ирүүлснээс гахайн аж ахуйн 3 нэгжид 535 сая, шувууны аж ахуйн 2 нэгжид 210 сая, загасны 1 аж ахуйд 90 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл тус тус олгогдсон байна. Мөн Хан-Уул дүүргийн 13 дугаар хороонд үйл ажиллагаа явуулдаг “Наш”ХХК нь Итали улсын бүрэн автомат тоног төхөөрөмжөөр үйлдвэрлэлээ өргөжүүлэн, өдөрт 40000 ширхэг өндөг авах боломж бүхий өргөтгөлийг ашиглалтад оруулсан байна.

Нийслэл хотод арьс шир боловсруулах 28 үйлдвэр үйл ажиллагаа явуулж, 2015 онд нийт 6,4 сая ширхэг арьс бэлтгэснээс, дотооддоо 2,2 сая ширхэг арьсыг гүн боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна.

2015 оны жилийн эцсийн байдлаар 8000 тн ноолуур бэлтгэснээс 3000 тонныг боловсруулсан бөгөөд хонины ноос 17500 тн, тэмээний ноос 820 тн бэлтгэгдэж боловсруулах шатанд явж байна.

2.3. Нийслэлийн Эдийн засаг, нийгмийн зорилтод тусгагдсан, тухайн байгууллагаас хийж гүйцэтгэх ажлын хэрэгжилт

Нийслэлийн Эдийн засаг, нийгмийн зорилтод тусгагдсан 2015 онд хэрэгжүүлэх 8 үйл ажиллагаанаас жилийн эцсээр 100%-4 ажил, 90%-2 ажил, 70%-2 ажил, дунджаар 90%-тай дүгнэгдсэн байна.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2013-2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЗААЛТ	2015 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХУВЬ
НЭГ. АГААР ЦЭВЭР УЛААНБААТАР		
1.2 Хөрс болон орчны бохирдлыг бууруулах чиглэлээр:		
1.2.3 Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж буй үйлдвэр, байгууллагыг хотоос гадагш нүүлгэх шат дараалсан арга хэмжээг авна.	Хан-Уул дүүргийн 13 дугаар хороо, Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр, шинэ суурьшлын бүсэд Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк байгуулах ажлыг эхлүүлнэ.	100
ГУРАВ. АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ УЛААНБААТАР		
3.5. Багануур дүүргийг хөгжүүлэх чиглэлээр:		

3.5.2 “Багануур” үйлдвэр, технологийн паркийн дэд бүтцийг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.	3-33.“Багануур” үйлдвэр, технологийн паркийн газрын асуудлыг шийдвэрлэж, үйлдвэрлэл технологийн парк байгуулах бэлтгэл ажлыг хангана.	70
3.7. Налайх дүүргийг хөгжүүлэх чиглэлээр:		
3.7.1 Орон нутгийн нүүрс, барилгын материалын түүхий эдийн нөөцийг түшиглэн бүх төрлийн барилгын материал, утаагүй түлшний үйлдвэрүүдийг цогцолбороор байгуулна.	Налайх дүүргийн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлыг эхлүүлнэ.	100
3.7.2 Дүүргийн төмөр зам, дэд бүтцийг ашиглан барилгын материалын бөөний худалдаа, ложистикийн төв болгон хөгжүүлнэ.	3-38.Төр ба хувийн хэвлийн түншлэлийн хүрээнд “Улаанбаатар ложистикийн төв” байгуулах төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	50
3.8. Эрчимжсэн МАА-н бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх:		
3.8.1. Улаанбаатар хотын сүүний хэрэглээний 80%-ийг дотоодын үйлдвэрлэлээр хангана.	3-39.Сүүний үйлдвэрлэлийг дэмжиж, Зээлийн батлан даалтын сан болон Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаар дамжуулан зээлд хамруулна.	100
3.8.2. Нийслэлийн Сонгино, Бөхөгийн орчмыг гахай, шувуу, загасны аж ахуй эрхлэх бүс болгон хөгжүүлнэ.	3-41.Гахай, шувуу, загасны аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, зээлд хамруулах ажлыг зохион байгуулна.	100
3.8.3 Нийслэлийн иргэдийн төмс, хүнсний ногооны хэрэгцээг бүрэн хангана.	3-42.Хөдөө аж ахуйн чиглэлээр ном, гарын авлага бэлтгэн сургалт, зөвлөгөөн зохион байгуулж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх боломжийг олгоно.	100
4.1.1 Архи, тамхи үйлдвэрлэх, худалдан борлуулахад тавих хяналтыг чангатгаж, хэрэглээний соёлыг төлөвшүүлнэ.	4-2.Согтууруулах ундаа, тамхины үйлдвэрүүдэд хяналт, шалгалт хийж, аттестатчилал явуулна.	100
Дундаж хувь		90%

Нийслэлийн Багануур дүүргийн нутаг дэвсгэрт Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах бэлтгэл ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий “Багануур Үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ыг НИТХТ-ийн 2015.07.03-ны өдрийн 122 дугаар тогтоолоор байгууллаа.

Улаанбаатар хотын зүүн талд ачаа тээврийн нэгдсэн ложистикийн төв байгуулах ажил нь газрын болон дуудлага худалдааны анхны үнийн төлбөрийг холбогдох байгууллага төлж барагдуулаагүй, хэрхэн төлөх асуудал эцэслэн шийдэгдээгүй тул хүлээгдэж байна.

2015 онд манай газраас нийслэлийн иргэдэд газар тариалан эрхлэх мэдлэг олгох нийт 18 сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 600 гаруй иргэдийг хамруулсан.

2.3. Нийслэлийн удирдлагаас цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт

Нийслэлийн удирдлагаас цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж, мэдээ тайланг цаг тухайд нь холбогдох байгууллагуудад хүргүүлж ажилласан. Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн 18 удаа болсноос манай байгууллагад нийтлэгээр 14 удаагийн үүрэг даалгавар өгсөн ба 100 хувийн биелэлттэй, тусгайлан заагдсан 1 үүрэг даалгаварын дагуу Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/870 дугаар захирамжаар Мал, тэжээвэр амьтдын тооллогын ажлыг зохион байгуулах комиссыг байгуулж, 2015 оны 12-р сарын 7-17 ны өдрүүдэд тооллогын ажил явагдаж, нийслэлийн мал бүхий 71 хороодын 186 чиглэлд тооллогч нар гарч ажилласан.

2.4. Иргэдийн өргөдөл, санал, гомдлын шийдвэрлэлт

1. 2015 онд манай газарт
 - Хүсэлт 29
 - Гомдол 5
 - Санал 1
 - Цахим системд бүртгэгдсэн нийт 35 өргөдлөөс хуулийн хугацаанд хариу өгсөн 34, хугацаа сунгаж хариу өгсөн 1, хугацаа хэтэрсэн болон хугацаандаа байгаа өргөдөл байхгүй байна.
2. Өргөдөл гомдлын хандалтын байдал:
 - 1200 тусгай дугаарын утсанд 5
 - Засгийн газрын 11 11 төвд хандсан 3
 - Иргэд хүлээн авах төвөөр дамжин ирсэн 6
 - Байгууллагад 21 өргөдөл тус тус цахим системд бүртгэгдсэн байна.
3. Өргөдөл гомдлын шат дамжлагыг дурьдахад:
 - Цахим системээр ирсэн өргөдлийг хэвлэн удирдлагад танилцуулна.
 - Удирдлагын цохолтын дагуу холбогдох хэлтсийн даргад цахимаар шилжүүлнэ.
 - Хэлтсийн дарга нар холбогдох мэргэжилтэндээ цохож шилжүүлнэ.
 - Мэргэжилтэн өргөдлийн хариуг удирдлагад танилцуулна.
 - Тухайн өргөдлийг эзэнд нь албан бичгээр эсвэл утсаар болон бусад байдлаар танилцуулна гэсэн үе шаттайгаар явагдаж байна.
4. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацаа:

2015 оны жилийн эцсийн байдлаар өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн хугацаа дунджаар 10 хоног 1 цаг 29 минут гарсан нь 1 өргөдлийг ажлын шаардлагаас шалтгаалан хугацааг дахин сунгаж 36 хоногт, 2 өргөдлийг бусад байгууллагатай хамтран 24 хоногт шийдвэрлэснээс шалтгаалсан байна.
5. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх чиглэлээр хийсэн ажил:
 - Нийслэлийн Засаг даргын тамгын газраас өгсөн зөвлөмжийн дагуу өргөдөл гомдлыг шийдвэрлэлтийн хугацааг 9 хоног дотор оруулахаар ажиллаж байна.
 - Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хийж байна.
 - Өргөдөл гомдлын хяналтын цонхыг мэргэжилтэн бүрийн компьютерт суулгасан

2.5 Архив, албан бичгийн шийдвэрлэлтийн талаар

- 2015 оны жилийн эцсийн байдлаар нийт 523 бичиг бүртгэн авч, хариутай 115 бичгийг хугацаанд нь шийдвэрлэж, 2 бичгийг хугацаа хэтэрч шийдвэрлэсэн байна. Сар бүрийн сүүлийн өдөр хариутай бичгийн шийдвэрлэлтийн мэдээнд хяналт тавьж ажиллалаа.
- Архив, албан хэрэг хөтлөлтийн тоон тайлан мэдээг Нийслэлийн архивын газрын tailan.ub.gov.mn сайтад зааврын дагуу шивж оруулсан.
- Улсын үзлэгийн өмнө урьдчилсан байдлаар 2015 оны 08 дугаар сарын 25-нд Нийслэлийн архивын газрын tailan.ub.gov.mn сайтад тоон мэдээллийг шивж оруулсан.
- Байгууллагын архивт бүртгэлтэй байгаа хадгаламжийн нэгжид бүртгэлийн дагуу тооллого явуулж, 2005-2014 онд үүссэн хадгаламжийн нэгжүүдийн бүрдэлд нөхөн бүрдүүлэлт, техник боловсруулалт хийж, ашиглалтын хуудас, баталгааны хуудсыг нөхөн бүрдүүлсэн.
- Газрын даргын А/13 дугаар тушаалаар Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсэг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, нэгдсэн дүнгээр 88.2% буюу (В) үнэлгээтэй дүгнэгдлээ.

- Архивын баримт түр олгох бүртгэлийг заавар журмын дагуу ашиглаж байна. Хадгалалтыг сайжруулах үүднээс сан хөмрөгийн чийг, дулаан хэмжих, цэвэрлэгээ үйлчилгээ хийх график гарган графикийн дагуу ажиллаж байна.
- Нийслэлийн Архивын газраас баталсан архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр дотооддоо сургалт зохион байгуулах графикийн дагуу архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтыг 3 удаа зохион байгуулж, 4 удаа зөвлөмж хүргүүлж, албан хаагчдаас төвшин тогтоох шалгалтыг 2 удаа авсан.
- Нийслэлийн Архивын газрын даргын баталсан "Цахим захирамжлалын баримт бичигт нягтлан шалгалт хийх ажлын удирдамж"-ийн дагуу 1978-2014 онуудад үүссэн нийт 1051ш захирамжлалын баримт бичигт цахим нягтлан шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, тайланг Нийслэлийн Архивын газарт хүргүүлсэн.
- Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/69 дугаар захирамжаар баталсан журмын дагуу манай байгууллага нийт 421 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй уулзаж, тэдгээр хүмүүст мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Уулзалтын журмыг нийт албан хаагчдад танилцуулж, газрын даргаар уулзалтын хуваарь батлуулсан. Уулзалтын тусгай хэсэг гаргаж, уулзалтыг гэрчтэй зохион байгуулан тэмдэглэл хөтлөж байна. Уулзалтын тайлан мэдээг цаг хугацаанд нь Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс хүргүүлсэн.

2.6. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээлэл

2015 оны Нийслэлийн төсөвт Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор Баянзүрх, Багануур, Багахангай, Налайх, Сонгинохайрхан дүүргүүдийн нутаг дэвсгэрт инженерийн хийцтэй гүний 10 ширхэг худаг гаргах НҮХААГ-15/01 дугаартай тендер зарлагдаж, "УС ИНЖЕНЕРИНГ" ХХК шалгарч гэрээ байгуулан ажилласан. Ажлыг гэрээний дагуу чанартай хийж гүйцэтгэн, 10 дугаар сарын 23-ны өдөр худгуудыг ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2015 оны Эрх шилжүүлэх тухай А/631 дүгээр захирамжаар "Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих" хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг баталсан. Уг захирамжийн хүрээнд "Бага оврын трактор болон ХАА-н машин, тоног, төхөөрөмж" худалдан авах, "ХАА-н дунд оврын трактор болон хадлангийн тоног төхөөрөмж" худалдан авах, "Гадна цахилгааны ажлыг гүйцэтгүүлэх", "Фермийн барилгажих 1.0 га талбайн хашаа барих", "Тэжээлийн талбай хаших, хайс барих" ажил болон "Бордоо нийлүүлэх", "Үрийн холимогийг нийлүүлэх" гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын тендерийг тус тус зарласан. "Бордоо нийлүүлэх", "Үрийн холимогийг нийлүүлэх" гүйцэтгэгчээр "Грийн химистри" ХХК шалгарч, 1,5 тн үрийн холимог, 20 тн нийлмэл бордоог гэрээнд заасан хугацаандаа нийлүүлж, ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн. "Бага оврын трактор болон ХАА-н машин, тоног, төхөөрөмж" худалдан авах тендерт зөвшилцлийн гэрээтэй "Мула" ХХК, "Зүлгэнтээг агрокорпораци" ХХК-нууд шалгарч, гэрээ байгуулан ажиллаж байна. Бусад зарласан тендерийн үнэлгээний ажил үргэлжлэн хийгдэж байна.

Гурав. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн

Төсвийн ерөнхийлөн захирагчаас ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгагдсан 11 зорилтын хүрээнд 24 арга хэмжээг хэрэгжүүлж, тайланг нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэв. Дундаж гүйцэтгэл 96 хувьтай байна.

Гэрээнд тусгагдсан нийт арга хэмжээ	Хэрэгжүүлэх үе шат	Хэрэгжилтийнхувь						Дүгнэгдээгүй
		100	90	70	50	30	10	
Ажил үйлчилгээ 1. Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт Хөнгөн үйлдвэрийн Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлыг эхлүүлнэ.	10	3	5	2				
Ажил үйлчилгээ 2. Тоосгоны шаврын орд ашиглагч ААН-үүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж, суурьшлын бүсэд үзүүлэх орчны нөлөөллийг бууруулах арга хэмжээг авна.	2	2						
Ажил үйлчилгээ 3. Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилгыг ханган ажиллана.	2	2						
Ажил үйлчилгээ 4. Хоёрдогч түүхий эдийг дахин боловсруулах үйлдвэрийн өнөөгийн байдал болон хэтийн төлвийг тодорхойлно.	3	3						
Ажил үйлчилгээ 5. Жижиг, дунд үйлдвэрлэлд зориулсан Зээлийн батлан даалтын механизмыг хэрэгжүүлнэ.	3	1	2					
Ажил үйлчилгээ 6. Төрийн бус байгууллагуудтай хамтран "Монголд үйлдвэрлэв-Цагаан сар 2015", "Улаанбаатар түншлэл", "Жижиг дунд үйлдвэрлэлийн техник технологийн үзэсгэлэн"-г тус тус зохион байгуулна.	5	5						
Ажил үйлчилгээ 7. Жижиг дунд үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх бодлого төлөвлөж боловсруулах хэрэгжүүлэх ажлыг зохицуулах, зохион байгуулна.	1		1					
Ажил үйлчилгээ 8. Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр хөтөлбөр, журам боловсруулна.	2							2
Ажил үйлчилгээ 9. "Багануур" үйлдвэрлэл технологийн паркийн газрын асуудлыг шийдвэрлэж, үйлдвэрлэл технологийн парк байгуулах бэлтгэл ажлыг хангана.	5	3		2				
Ажил үйлчилгээ э 10. Налайх дүүргийн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлыг эхлүүлнэ.	8	5	2	1				
Ажил үйлчилгээ 11. Төр ба хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд "Улаанбаатар ложистикийн төв" байгуулах төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	4	1			3			
Ажил үйлчилгээ 12. Улаанбаатар хотын үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн төлөвлөлтийн санал боловсруулна.	2	2						
Ажил үйлчилгээ 13. Бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулна.	4	4						
Ажил үйлчилгээ 14. Сүүний үйлдвэрлэлийг дэмжиж, зээлийн батлан даалтын сан болон Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаар дамжуулан зээлд хамруулах ажлыг зохион байгуулна.	35	35						
Ажил үйлчилгээ 15. Гахай шувууны аж ахуй эрхлэгчдийн үйлажиллагааг дэмжиж, зээлд хамруулах ажлыг зохион байгуулна.	6	6						

Ажил үйлчилгээ 16. Хөдөө аж ахуйн чиглэлээр гарын авлага, зөвлөмж бэлтгэн гаргах, зөвлөх үйлчилгээг үзүүлэх, газар тариалангийн үйлдвэрлэлийг эрхлэх боломжийг олгох сургалт зохион байгуулах	10	9		1				
Ажил үйлчилгээ 17. Хэрэглэгчдийг хямд үнэтэй эх орны хөрсөнд ургасан хүнсний ногоогоор хангахад чиглэсэн ажил үйлчилгээ зохион байгуулна.	3	3						
Ажил үйлчилгээ 18. Жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлж, "Чацаргана" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	4	4						
Ажил үйлчилгээ 19. Хүнсний ногооны зоорины багтаамжийг нэмэгдүүлэхэд хамтран ажиллана.	2	2						
Ажил үйлчилгээ 20. Хүлэмжийн аж ахуй үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	1	1						
Ажил үйлчилгээ 21. "Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх" төслийг хэрэгжүүлнэ.	5	4			1			
Ажил үйлчилгээ 22. Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор гадаад, дотоодын Төрийн болон Төрийн бус байгууллагатай хамтран ажиллана.	6	6						
Ажил үйлчилгээ 23. Атаршсан болон ашиглалтгүй талбайг эргэлтэд оруулах, газар ашиглалтыг сайжруулна.	1	1						
Ажил үйлчилгээ 24. Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, шинээр ажлын байр бий болгоно.	4	4						
ДҮН	128	106	10	6	4			2

“Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр хөтөлбөр, журам боловсруулна” гэсэн ажил үйлчилгээ нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 26/08 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын эдийн засгийн стратеги” баримт бичиг болон НИТХТ-ын 2015 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 133 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн Үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх хөтөлбөр”-т тусгагдсан зорилтууд агуулгын хувьд давхцаж байгаа тул уг хөтөлбөрийг боловсруулан батлуулах шаардлагагүй гэж Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал харицсан орлогч Т.Бат-Эрдэнэ шийдвэрлэсэн.

2015 онд улсын хэмжээнд гандуу, бороо хур багатай байснаас шалтгаалан төмс, хүнсний ногооны ургац багатай байсан. Нийслэлийн хувьд иргэд газар тариалан эрхлэх мэдлэг болон өвчин хортноос хамгаалах, усыг ариг гамтай ашиглах, ганд тэсвэртэй сортыг сонгон тариалах чиглэлээр давуу мэдээлэл, арга зүйн зөвлөгөө авсан. Мөн мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн дүүргүүдэд бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Нийслэлийн төсвийн хөрөнгөөр анх удаа инженерийн хийцтэй 10 ширхэг худаг гарган дүүргүүдийн Засаг даргын тамгын газарт хүлээлгэж өглөө.

Дөрөв. Дүрмээр хүлээсэн үүргийн биелэлт

1. Монгол Улсын Засгийн газрын болон нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн тухайн жилийн зорилтод нийслэлийн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх бодлогыг тусгуулан батлуулж, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн ажлыг зохион байгуулах

- Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн Эдийн засаг, нийгмийн 2015 оны зорилтод 8 хэрэгжүүлэх ажил тусгуулж, хэрэгжилтийг 90 хувь ханган ажилласан. 2016 оны нийслэлийн төсвийн төсөлд хэрэгжүүлэх арга хэмжээ, төсвийн талаарх саналыг боловсруулж, хүргүүлсэн.
- Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санал, Монгол улсын Эдийн засаг нийгмийг 2016 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төсөлд салбарын танилцуулга болон хөгжлийн төсөөллийн талаар боловсруулан, НЗДТГ-ын СБТХ-т хүргүүлэв.

2. Нийслэлийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан үйлдвэржүүлэлт, эрчимжсэн мал аж ахуй, газар тариалантай холбоотой төсөл хөтөлбөр, түүний зураг төсөл, техникийн даалгаврыг хянаж санал оруулах

- ҮТП-ийн техник, технологийн түвшний үнэлгээ хийх ажлын даалгаврыг боловсруулж, газрын даргаар батлуулан ЭХҮҮТПарк ОНӨТҮГазарт хүргүүлэв. ЭХҮҮТПаркаас Зөвлөх үйлчилгээний тендерийг 2015 оны 11 дүгээр сарын 09 өдөр зарлаж, ШУТИС-Бизнесийн Удирдлага Хүмүүнлэгийн Ухааны Сургууль шалгарч, гэрээ байгуулах шатандаа явж байна.
- 2014 оны Нийслэлийн Засаг Даргын А/836 дугаар захирамжаар Налайх дүүргийн үйлдвэр технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажилд 180,0 сая төгрөгийг нийслэлийн төсвийн хөрөнгөөр шинээр баригдах барилга байгууламж, авто зам, инженерийн шугам сүлжээний зураг төсөв, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хөрөнгөнөөс гаргах шийдвэр гарсан. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас нээлттэй тендер сонгон шалгаруулалт зарлагдаж, “Арт констракшн” ХХК шалгаран НЕТГ-тай гэрээ байгуулан ажилласан. Гэрээнд заасан хугацааны дагуу 2015 оны 06 сарын 11-нд дундын тайланг НЕТГазрын техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн зарим нэмэлт ажлуудыг хийхээр шийдэлд хүрсэн. 2015 оны 07 сарын 09-ний өдрийн хурлаар төгсгөлийн шатны тайланг хэлэлцэн, экспертизийн магадлалыг гаргуулахаар Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн.
- 2015 оны Нийслэлийн хөрөнгө оруулалтын төсөл, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2016 оны зорилтын төсөлд мал аж ахуйн талаарх хийж, хэрэгжүүлэх ажлуудын төсвийн саналыг боловсруулан холбогдох газарт хүргүүлээ. “Цогцолбор ферм байгуулах” ажилд дэмжлэг авахаар холбогдох саналыг тусгасан тогтоолын төслийг боловсруулан, төсөлд шаардлагатай мэдээ, судалгаа, танилцуулгыг бэлтгэн, төслийн саналыг ХХААЯ-нд хүргүүлээд байна.
- НЗД-ын 2014 оны 06 дугаар сарын 27 өдрийн А/547 дугаар захирамжаар байгуулагдсан Улаанбаатар хотын эдийн засгийн хөгжлийн стратеги боловсруулах Удирдах хорооны Хөгжил дэвшлийн асуудал эрхэлсэн салбар хороонд ажиллаж, НИТХ-ын 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 26/08 дугаар тогтоолоор батлуулсан. “Улаанбаатар хотын эдийн засгийн стратеги” баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд үйлдвэрлэлийн салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан, НЭЗХГ-т хүргүүлэв.
- “Цогцолбор ферм байгуулах”, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөр, “Монгол мал” дэд хөтөлбөр, “Нийслэлд мал аж ахуй эрхлэх” журмын төсвийн төслийг боловсруулан, үр өгөөжийг тооцон Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар болон Япон улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага JICA-ийн төслийн багт холбогдох материалын хамт хүргүүлээ.

3. Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан үйлдвэржүүлэлт, хөдөө аж ахуйн бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулна

- Нийслэлийн 2015 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 24/04 дүгээр тогтоолоор Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн паркийн ажилд 1,2 тэрбум төгрөг, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл технологийн паркийн ажилд 1,8 тэрбум төгрөгийг тус тус батлуулсан.
- Нийслэлийн 2015 оны хөрөнгө оруулалтын зардлаас 495 сая төгрөгийг Нийслэлийн Засаг даргын 2015 оны 5 дугаар сарын А/460 дугаар захирамжаар Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн Үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-т паркад захиран зарцуулах эрх шилжсэн.
- Паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотголд 120 сая төгрөг, Барилга угсралтын үеийн цахилгаан хангамжийн ажилд 375 сая төгрөгийг зарцуулахаар тус тус шийдвэрлэсэн. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн Үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын даргын 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн А/40 тушаалын 2 дугаар хавсралтаар байгуулан ажиллаж байна. Эмээлтийн хөнгөн ҮТП-ийн техник, технологийн түвшний үнэлгээ хийлгэхэд шаардлагатай 23,7 сая төгрөгийг НЗД-ын 2015 оны 11 сарын 04-ний өдрийн “Эрх шүлжүүлэх тухай” А/867 дугаар захирамжаар шийдвэрлүүлж, ҮТП-ийн техник, технологийн түвшний үнэлгээ хийх ажлын даалгаврыг боловсруулж, газрын даргаар батлуулан, ЭХҮҮТПарк ОНӨТҮГазарт хүргүүлэв. ЭХҮҮТПаркаас ҮТП-ийн техник, технологийн түвшний үнэлгээ хийх ажлын Зөвлөх үйлчилгээний тендерийг 2015 оны 11 сарын 09-ний өдөр зарлаж, ШУТИС-Бизнесийн Удирдлага Хүмүүнлэгийн Ухааны Сургууль шалгарч, гэрээ байгуулах шатандаа явж байна.
- Паркийн газрын доорх усны хайгуул хийж, нөөц тогтооход 350 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлж сонгон шалгаруулалтыг явуулж “Эрдэнэ дрийнлинг” ХХК шалгарч, ажлын даалгаврын дагуу геофизикийн судалгаа явуулж 7 цэгт өрөмдлөг хийж, нөөцийг тогтоон, өрөмдлөгийн ажлыг явуулан, улсын комисст хүлээлгэж өгөхөд бэлэн болоод байна. Үйлдвэрлэл, технологийн паркийн хашаа болон түр захиргааны байр барих ажлын даалгаврыг боловсруулж, Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газраар батлуулсан. Захиргааны түр байрыг оффис нэг цэгийн үйлчилгээний барилга хэлбэрээр барьж, 12 дугаар сард ашиглалтанд оруулна.
- НИТХТ-ийн тогтоолоор батлагдсан журмын дагуу Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/138 дугаар захирамжаар нийслэлийн хөдөө аж ахуйн салбарт ажиллагсадын шагналд зарцуулагдах 27047,6 мянган төгрөгийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлсэн.
- Мал аж ахуйн салбарын 2015-2016 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, дүүргүүдэд өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх зорилгоор Засаг даргын А/736 дугаар захирамжаар 202 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн.
- Нийслэл орчимд малын бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор 10 ширхэг гүний өрмийн худаг гаргах саналыг боловсруулан, Нийслэлийн засаг даргын тамгын газарт хүргүүлж, нийслэлийн төсөвт 178,5 сая төгрөг батлуулсан.
- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай 3010,0 сая төгрөгийг нийслэлийн төсвөөс гарган санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн.

4. Нийслэлийн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарын мэдээллийн санг бүрдүүлж, түүний баяжилтыг тогтмолжуулна

- Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагын 70 хувь буюу 71654 нь Улаанбаатар хотод бүртгэлтэй байдаг бөгөөд 34777 нь жилийн турш идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна. Нийслэл хотын 2530 гаруй боловсруулах үйлдвэр, цехэд 55500 орчим хүн ажиллаж байна.
- Нийслэлийн аж үйлдвэрийн газрууд 2015 оны эхний хагас жилд 2771.8 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 3498.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад үйлдвэрлэлт 2.9 хувиар буурч, борлуулалт 6.8 хувиар өссөн байна.
- Нийслэлийн аж үйлдвэрийн салбарын 2015 оны эхний хагас жилийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн 59.3 хувийг олборлох, 7.7 хувийг дулаан эрчим хүч үйлдвэрлэлт, 33.0 хувийг боловсруулах үйлдвэрлэлт тус тус эзэлж, 2014 онтой харьцуулахад хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 30.5 хувиар өсч, боловсруулах үйлдвэрлэлт 0.3 хувиар буурсан байна.
- Нийслэлийн ЖДҮ-ийг Дэмжих төвтэй хамтран цахим бүртгэлийн систем нэвтрүүлэн, www.jdu.ub.gov.mn цахим хаягт 1734 үйлдвэр эрхлэгчдийн бүртгэл, 63 нэр төрлийн эрх зүйн акт, арилжааны банкуудаас жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр гаргаж буй зээлүүд, гадаад дотоодын төрийн болон төрийн бус байгууллагуудын жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд зэрэг 25 нэр төрлийн мэдээлэл бүхий мэдээллийн сангаар үйлдвэр эрхлэгчдэд үйлчилж байна.
- Мөн ЖДҮ-ийн Сургалт мэдээллийн төвийн цахим мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, цахим номын санд 1070 ширхэг, 25 төрлийн ном товхимол, гарын авлагаар жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үйлчилж байна.
- Монгол улсын Засгийн газрын 2015 оны 122 дугаар тогтоолоор батлагдсан “Үндэсний боловсруулах үйлдвэрт хонины ноос, тэмээний ноос бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам” – ын дагуу 2015 онд ноосны урамшуулалд нийслэлийн 6 дүүргийн 245 малчны тушаасан 62089.0 кг ноосны урамшуулалд 62089,0 мян.төгрөг, арьс ширний урамшуулал авахаар 228 малчин, мал бүхий иргэн материал ирүүлснээс 185 малчинд 39645,0 мян. төгрөгийн урамшуулал олгогдоод байна.
- Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан NLIS программд 10000 бог малын мэдээллийг оруулсан. Малын үндэсний бүртгэл мэдээллийн систем хяналтын онлайн программд 2015 оны мал төллөлтийн мэдээ болон нийслэлийн 22 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн мэдээллийг оруулж, баяжилт хийсэн. Мөн малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан NLIS программаас Малын үндэсний бүртгэл мэдээллийн систем хяналтын онлайн программ руу 39412 малын бүртгэл, малын эзний мэдээллийг хөрвүүлж оруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.
- Нийслэлд газар тариалан эрхлэж буй иргэд, аж ахуйн нэгжүүдийн судалгааг тарималын нэр төрлөөр дүүрэг тус бүрээр гаргаж, тариалалт болон ургац хураалтын мэдээг дүүрэг, тарималын төрөл бүрээр гарган холбогдох дээд байгууллагуудыг мэдээ мэдээллээр ханган ажилласан. Мэдээллийн санг шинэчлэж, ургалтын явцын байдалд хяналт тавьж зааварчилгаа өгөх зорилгоор 2015 оны 6 дугаар сарын 24-30-ны өдрүүдэд Нийслэлийн 5 дүүргүүдийн 20 хорооны тариалалтын байдал, төмс, хүнсний ногооны худалдааны төвлөрсөн цэгүүдийн үйл ажиллагааг жигдрүүлэх ажлыг зохион байгуулж, нийт 40 аж ахуй нэгж, 60 гаруй өрхийн тариалангийн 170 гаруй хүлэмж 40 га ил талбайн тариалалтаар явж заавар, зөвлөмж өгч ажилласан.

5. Үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарт олгосон гадаадын зээл тусламжийн хөрөнгийг нийслэлийн үйлдвэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх зорилгод ашиглах асуудлыг холбогдох дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэн зохицуулах

- Улаанбаатар хот дахь хаягдал ус зайлуулах үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор Европын Сэргээн босголт хөгжлийн банктай 2014 оны 12 сарын 05-ны өдөр МАНДАТЫН БИЧИГ байгуулсан. Уг мандат бичгээр төслийн нийт дүн 30 сая евро ба 15 сая хүртэл евро Европын Сэргээн босголт хөгжлийн банкны зээл, 15 сая хүртэл евро Азийн хөгжлийн банкны зээл болон буцалтгүй тусламжаар хамтран санхүүжүүлж, барихаар ажиллаж байна. Европын Сэргээн босголт хөгжлийн банкны судалгааны зөвлөх баг 2015 оны 04 дүгээр сард Монголд ирж Эмээлтийн үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаатай танилцаж, цэвэрлэх байгууламж барих ТЭЗҮ-ийн урьдчилсан судалгааг хийж, 8 дугаар сард нийслэлийн Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогчид танилцуулж, судалгаанд шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг хийж, Европын Сэргээн босголт хөгжлийн банкны эхний шатны хурлаар хэлэлцүүлсэн. Мөн Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас зээлийн гэрээний төслийг боловсруулж ирүүлээд байна.

6. Улаанбаатар хотын хөгжил, эрэлт хэрэгцээнд нийцсэн ажлын байрыг бий болгох арга хэмжээг төрийн захиргааны төв байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх

- Баялаг бүтээгчдийг дэмжих аяны хүрээнд Аж үйлдвэрийн яам, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн тэнхим, Налайх дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо, Зээлийн батлан даалтын сантай хамтран “Баялаг бүтээгчид Налайх дүүрэгт” зөвлөгөөнийг зохион байгуулсан. Тус зөвлөгөөнд Налайх дүүрэгт жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг хувь хүн, аж ахуйн нэгжийн 100 орчим төлөөлөл оролцсон бөгөөд “Налайхын барилгын материалын Үйлдвэрлэл, технологийн парк” дэлгэрэнгүй мэдээллийг иргэдэд танилцуулав. Налайх дүүрэгт НБМҮТПарк ОНӨТҮГазрын салбарыг нээн үйл ажиллагаагаа явуулж паркт байрших үйлдвэрүүдэд шинээр бий болох 1500 ажлын байранд дүүргийн иргэдийг зуучлах, хувь хүний хөгжлийг дэмжих замаар бэлтгэх, сургалт судалгаа мэдээллийн төвийг ажиллуулж байна.
- Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэж буй иргэдэд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх технологийн мэдлэг олгох сургалтуудыг үе шаттайгаар зохион байгууллаа. 2015 онд 16 сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 1000 гаруй тариаланчдыг хамрууллаа. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх талаарх мэдлэг олгосноор өрх хэрэгцээт төмс, хүнсний ногоо тариалах, өрхөд ажлын байр бий болох, өрхийн орлого нэмэгдэх зэрэг олон талын ач холбогдолтой.

7. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулдаг үйлдвэрийн газруудад Монгол Улсын хууль тогтоомж, норм норматив, дүрэм, журмын дагуу үйл ажиллагаагаа явуулахад нь арга зүйн зөвлөгөө өгөх, хэрэгжилтийг хангуулж, гарсан зөрчлийг арилгах асуудлыг холбогдох байгууллагуудад нь уламжилан, хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлүүлэх

- Архи, тамхины үйлдвэрүүдийн тусгай зөвшөөрөл сунгуулахаар 2015 оны эхний хагас жилийн байдлаар шар айрагны 3, архины 2, спиртийн 1 нийт 6 үйлдвэр хүсэлт ирүүлж, шалгалт хийсэн. “Арвайн ундрага” ХХК-ийн архины үйлдвэр дунд эрсдэлтэй, барилга байгууламж стандарт, техникийн зохицуулалтанд нийцэхгүй байгаа тул зөрчлийг арилгах хүртэл үйл ажиллагаа явуулах боломжгүйг НЗД-ын томилсон ажлын хэсэг тогтоосон байна.
- Улаанбаатар хотод малын гаралтай ноосон түүхий эдийг оруулахгүй байх талаар Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч, Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын удирдлагууд, Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн

- холбооны удирдлагуудтай уулзах уулзалтыг 2015 оны 03 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан. Анхан шатны боловсруулалт хийгдээгүй малын гаралтай ноосон түүхий эдийг Нийслэл хот руу оруулахгүй байх талаар мэргэжлийн байгууллагуудын саналыг үндэслэн Нийслэлийн Засаг даргын 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А/230 дугаар захирамж гарсан Нийслэлийн Засаг даргын 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн “Ноос боловсруулах үйлдвэрүүдийн талаар авах арга хэмжээний тухай” А/230 дугаар захирамж гарсан. Захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд: Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй арьс шир, ноос ноолуур, цаас боловсруулах үйлдвэрүүдийн технологийн хаягдал ус, боловсруулах үйлдвэрт тавигдах ерөнхий шаардлага, стандартын хэрэгжилтийг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 02-01/702 дугаар удирдамжийн дагуу 2015 оны 09 дүгээр сарын 9-22-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Тус шалгалтанд арьс шир боловсруулах 22, ноос ноолуур боловсруулах 13, ахуйн цаасны 4 нийт 39 аж ахуйн нэгж хамрагдлаа. Нэгдсэн тайлан дүгнэлтийг Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Т.Бат-Эрдэнэд 2015 оны 10 дугаар сарын 27-ны өдөр танилцуулсан. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас 16 аж ахуйн нэгжид 99 заалт бүхий зөрчил арилгуулах улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлсэн. Арьс шир, ноос ноолуур боловсруулах болон ахуйн цаасны үйлдвэрүүдийн технологийн хаягдал усанд хийсэн шинжилгээний дүнг үндэслэн стандартын шаардлага хангаагүй 17, хангасан 15 байна гэсэн дүгнэлт гаргасан.
- НЗД-ийн Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогчийн 2014 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн удирдамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2015 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр хуралдан, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулахаар шийдвэрлэсэн. Шийдвэрийн дагуу 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/491 дүгээр захирамжаар Сонгинохайрхан дүүргийн шаврын ордод олборлолт хийж буй аж ахуйн нэгжүүдэд арга хэмжээ авч ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан. Ажлын хэсэг хуралдаж 3 жилийн хугацаанд аж ахуйн нэгжүүдийг үйл ажиллагаагаа явуулахыг зөвшөөрсөн шийдвэр гаргасан.
 - Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран 2015 оны 03 дугаар сарын 16, 04 дүгээр сарын 20-ны өдрүүдэд түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд 2 удаагийн сургалтыг зохион байгуулж зөвлөмж, гарын авлага материал олгосон. Сургалтанд нийт 56 аж ахуйн нэгж хамрагдсан. Сургалтаар ОУИТБС-ын ажлын албанаас 2015 оноос олборлох үйлдвэрүүдийн тайланг цахимаар авах болсонтой холбогдуулан цахим тайлан гаргахад анхаарах асуудлуудын талаар болон холбогдох хууль, эрх зүйн актуудын талаар мэдээлэл хийсэн. НЗД-ын А/635 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Налайх дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа шаврын орд ашиглах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг явуулж, зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээ үзүүлсэн. Шалгалтын дүнг НЗД-ын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч, газрын дарга нарт танилцуулж, мөн НИТХ-д танилцуулга бэлтгэж хүргүүлсэн.
 - Дүүргүүдийн Засаг дарга нарт зориулсан “Уул уурхайн үйлдвэрлэл эрхлэх болон олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэхэд орон нутгийн удирдлагын оролцоо, эрх үүрэг” сэдэвт сургалтыг 04 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулж зөвлөмж гарын авлагаар хангасан. Сургалтанд 9 дүүргийн Засаг даргын орлогч, тамгын газрын дарга, холбогдох мэргэжилтнүүд нийт 14 хүн хамрагдсан. Мөн нийслэлийн нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд 3 удаагийн сургалт, семинарыг зохион байгуулж ном, гарын авлагаар хангасан. Сургалтанд нийт 56 аж ахуйн нэгж хамрагдсан.
 - Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын газартай хамтран “Намрын ногоон өдрүүд-2015” нэгдсэн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан “Алтан намар-2015” шинэ

ургацын төмс, хүнсний ногооны үзэсгэлэн худалдааны үеэр явуулын лаборатори ажиллуулан тус худалдаанд бүтээгдэхүүнээ борлуулсан 17 аймаг, нийслэлийн 6 дүүргийн нийт 250 гаруй ногоочин, 4 аж ахуйн нэгж, 12 хоршоо, 4 төсөл хөтөлбөрийн хүнсний ногооны чанар аюулгүй байдалд хяналт тавьж, баталгаатай хүнсийг иргэдэд нийлүүлэхэд анхаарч ажилласан.

- “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын үзүүлэлт, хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл” сэдэвт сургалтыг МХЕГ-ын ХАБҮЛЛ, НМХГ-тай хамтран 2015 оны 05 дугаар сарын 26-ны өдөр зохион байгууллаа. Сургалтанд нийслэлийн 12 аж ахуйн нэгжийн 19 чанарын менежер, лабораторийн эрхлэгч, шинжээч, эрүүл ахуйч нар хамрагдав. Сургалтаар “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн талаархи ойлголт”, “Хор судлалын үзүүлэлт, эрүүл мэндийн нөлөө”, “Нян судлалын үзүүлэлт, эрүүл мэндийн нөлөө”, “Сүү, сүүн бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлт”, “Ундаа жүүс, усны аюулгүйн үзүүлэлт”, “Төмс, хүнсний ногооны аюулгүйн үзүүлэлт”, “Хүнсний бүтээгдэхүүний цацрагийн байдал, хяналт зэрэг үндсэн ойлголт” мэдээллээр хангасан
- Хүнсний худалдааны сүлжээнээс 17 нэрийн архи, 3 нэрийн дарс, 5 нэрийн шар айрагнаас дээж авч, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн нэгдсэн төв лабораторид 132 үзүүлэлтээр шинжлүүлэхэд 12 нэрийн согтууруулах ундаа шаардлага хангаагүй гарсны 8 нь архи, 2 нь дарс, 2 нь шар айраг байна. Эерэг гарсан үзүүлэлтээр нь авч үзвэл 50 хувь нь хатуулаг буюу этилийн спиртийн агууламж шошго дээр тэмдэглэснээс зөрүүтэй, 33.3 хувьд мэдрэхүйн үзүүлэлтээр буюу гадны механик хольцтой, үлдсэн хувьд альдегид стандартаас их, дарсны хүчиллэгийн хэмжээ зөрүүтэй байгаа нь тогтоогдлоо. Сүүлийн 5 жилийн согтууруулах ундааны сорилтын дүнд судалгаа хийж үзэхэд эерэг сорьцын эзлэх хувь 2010 онд 17.8%, 2011 онд 9.6%, 2012 онд 28.9% 2013 онд 10.7 %, 2014 онд 8,07% болж, сүүлийн онд өмнөх онуудаас дунджаар 10-20.8 хувиар эерэг сорьцын эзлэх хувь буурсан үзүүлэлт харагдаж байна.

8. Хотын хөгжлийн хэтийн төлөв, бодлогод тусгагдсан үйлдвэржүүлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэл, дүүргийн аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран ажиллах

- Улаанбаатар хотын төлөвлөлтийн Баруун-2 бүсийн Үйлдвэр 1-р хорооллын ерөнхий төлөвлөгөөг “АРКЕТАЙП МОНГОЛИА” ХХК, Үйлдвэр 2, 3-р хорооллын ерөнхий төлөвлөгөөг Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн ОНӨҮГ гүйцэтгэж байгаа бөгөөд Нийслэлийн Зураг төслийн хүрээлэнтэй хамтран “Үйлдвэр-1, 2, 3” хорооллын ерөнхий төлөвлөлтийн талаар харьяа агентлагууд, мэргэжлийн холбоодтой санал солилцох уулзалтыг 2015 оны 04 дүгээр сард тус тус зохион байгуулсан.
- Монгол Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”-т тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл, НИТХ-ын 2015 оны 26/08 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын эдийн засгийн стратеги” баримт бичигт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд үйлдвэрлэлийн салбарын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулж, холбогдох газруудад хүргүүлэв.
- Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/932 дугаар захирамжийн хүрээнд 2014 оны 02 дугаар сарын 27-ны өдөр Нийслэлийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөны тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичигтэй уялдуулан салбарын хөгжлийн хэтийн төлөв, “Үйлдвэрлэл технологийн парк”-ийн талаар Нийслэлийн ЗДТГ-ын Стратеги бодлого төлөвлөлтийн хэлтэс, Нийслэлийн Эдийн

засгийн хөгжлийн газар, Улаанбаатар Бизнес Хөгжлийн Төв, Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо, үйлдвэрлэгчид болон Барилгын материалын үйлдвэрлэл технологийн паркийн ТЭЗҮ-г боловсруулж байгаа Арт констракшн ХХК-ны төлөөлөл оролцсон уулзалтыг зохион байгуулан ТЭЗҮ-ийн ажлын явц, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар санал солилцсон.

- “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн Үйлдвэрлэл, технологийн парк”, Багануур дүүргийн Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд 2014 оны 11 сарын 4-ний өдөр ҮХААЯамны Хөнгөн үйлдвэрийн бодлого зохицуулалтын газрын орлогч, Арьс ширний үйлдвэрлэлийн холбоо, Багануур дүүргийн ТЭЗҮ хийсэн багийн ахлагч, Багануур дүүргийн газрын албаны дарга, Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэрлэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн болон холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөлөл оролцож, 2015 оны НЭЗНЗорилтод орох саналыг танилцуулж, санал солилцсон.
- Налайх дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа шаврын орд ашиглах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн удирдлагуудад мэргэжил аргагүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах сургалтыг Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлал, геологи, уул уурхайн хэлтэс, Дэд бүтцийн хяналтын хэлтэс, Санхүү, хөдөлмөр, нийгмийн хамгааллын хэлтэс, Нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газар, Нийслэлийн үйлдвэр, хөдөө аж ахуйн газар, Налайх дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс зэрэг байгууллагууд хамтран 2014 оны 03 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан. Сургалтанд Налайх дүүргийн нутаг дэвсгэрт тоосгоны үйлдвэрлэл эрхлэгч 28 аж ахуйн нэгжийн 35 төлөөлөл хамрагдлаа. Аж үйлдвэрийн сайд, Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 01 дүгээр сарын 22-ны өдрийн хамтарсан тушаал, захирамжаар “Монголд үйлдвэрлэв, Цагаан сар-2015” үзэсгэлэн худалдааг 01 дүгээр сарын 28-ны өдрөөс 02 дугаар сарын 04-ний өдрүүдэд 9 дэх жилдээ зохион байгууллаа.
- Үндэсний үйлдвэрлэлийг сурталчилах, дэмжих, импортын бүтээгдэхүүний хэрэглээг багасгах “Үндэсний Үйлдвэрлэлээ дэмжицгээе” уриан дор 80 гаруй аж ахуйн нэгж, үйлдвэр эрхлэгчид оролцож, нийтдээ 3 тэрбум орчим төгрөгийн борлуулалт хийгдсэн. Энэхүү үзэсгэлэн худалдаанд нийслэлийн 6 дүүрэг, байнгын ажиллагаатай “Монголд үйлдвэрлэв” худалдааны 2 төвөөр дамжуулан нийт 800 гаруй аж ахуйн нэгж болон өрхийн үйлдвэрлэгч, бичил бизнес эрхлэгчид оролцсон.
- Сонгинохайрхан дүүргийн Худалдаа үйлчилгээний хэлтэстэй хамтран 2015 оны 03 дугаар сарын 31-ний өдөр “Үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчдийн зөвлөгөөн”-ийг зохион байгуулав. Зөвлөгөөнд НҮХААГ-ийн дарга Г.Пүрэвсүрэн оролцож “Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний тухай танилцууллаа.
- Нийслэлийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн хоёрдугаар зөвлөгөөнийг ЖДҮДТөвтэй хамтран 2015 оны 08 дугаар сарын 06-ны өдөр Нийслэлийн ЖДҮ-ийг дэмжих төвийн Сургалт мэдээллийн төвд зохион байгууллаа. Уг зөвлөгөөнд нийслэлийн 9 дүүргийн ЖДҮ эрхлэгчдийн төлөөлөл болох 98 иргэн, аж ахуйн нэгж хамрагдсан бөгөөд зөвлөгөөнөөс гарсан санал, дүгнэлтийг Нийслэлийн Эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилтод тусгуулахаар саналаа өгөөд байна.
- БОНХАЖЯ, МҮХАҮТ-тай хамтран “Ногоон технологи 2015” үзэсгэлэнг 2015 оны 09 дүгээр сарын 20, 21 өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Мөн үзэсгэлэнгийн үеэр “Ногоон технологи 2015” хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Үзэсгэлэнд нарны эрчим хүч, дулааны алдагдал багатай барилгын материал, усны хэмнэлттэй болон бохир ус цэвэрлэх технологи, биобордоо, автомашины утаа багасгах устөрөгчийн генератор, биотүлшний үйлдвэрлэл, худалдаа хийдэг нийт 42 аж ахуйн нэгж байгууллага, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд оролцсон.

- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Ерөнхийлөгчийн 2015 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/731/216 дугаар хамтарсан захирамж, тушаалаар “Улаанбаатар түншлэл-2015” Олон улсын үзэсгэлэн яармагийг 2015 оны 09 дүгээр сарын 10-14-ний өдрүүдэд 19 дэх жилдээ Мишээл Экспо төвд амжилттай зохион байгууллаа. Үзэсгэлэн яармагт ОХУ, БНСУ, Тайвань, Непаль зэрэг 10-аад улс орноос нийт 30 гаруй аж ахуйн нэгж, дотоодын 100 гаруй үйлдвэрлэл эрхлэгчид оролцсон бөгөөд 18 номинацийн төрөлд 81 аж ахуйн нэгж өрсөлдөж, үзэсгэлэнгийн дээд шагнал болох “Гран при”-ийг “Очир дагинас” ХХК хүртэж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн нэрэмжит өргөмжлөлийг “Энхжин сувенир” ХХК, “Хаан хүнс сүлжээ” ХХК тус тус хүртлээ.
- Намрын ногоон өдрүүд-2015” үзэсгэлэн 09 сарын 26-27-ны өдрүүдэд Чингисийн талбайд болж, нийт 60 гаруй аж ахуйн нэгж байгууллагуудыг хамрууллаа Хүнс, хөдөө аж ахуйн салбарын “Намрын ногоон өдрүүд-2015” нэгдсэн арга хэмжээний “Алтан намар-2015” үзэсгэлэнд 17 аймаг, нийслэлийн 6 дүүргийн 250 ногоочин, 4 аж ахуй нэгж, 12 хоршоо, 4 төсөл төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, ногооны үр, модны суулгац эмийн ургамлын бүтээгдэхүүнээр оролцож, 420 тн төмс, 450 тн хүнсний ногоо, 5000 шил нөөшилсөн ногоо, 1,9 тн зөгийн бал, 150 килограмм байгалийн эмийн ургамал, 1.8 тонн чацаргана, 0.1 тн үхрийн нүд, 3.5 тн байгалийн жимс борлуулсан байна. Харин суулгацын хувьд 12000 ширхэг чацарганы суулгац, 6000 ширхэг улаалзгана, 2000 ширхэг интоор, 1500 ширхэг гүйлс, 500 ширхэг чимэглэлийн суулгац, 100 ширхэг тасалгааны цэцэг зэрэг бүтээгдэхүүнээр нийт 828.9 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.
- Аж үйлдвэрийн яам, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран 2015 оны 06 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд Мишээл экспо төвд Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологи - 2015” олон улсын үзэсгэлэн яармагийг амжилттай зохион байгууллаа. Үзэсгэлэнд Монгол, БНХАУ, Польш, БНЧУ, ӨМӨЗО, БНАСУ, Тайван улсын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй нийт 110 гаруй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид оролцсон бөгөөд "Аз хур" ХХК Дэлхийн жүжгийн дээжис 11 боть номоороо Гран при шагналыг хүртлээ.

9. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн үйлдвэржүүлэлтийн бодлогын хэрэгжилтийн биелэлтийг нэгтгэн гаргахад шаардагдах судалгаа, тооцоо, мэдээллийг Захирагчийн ажлын албаны хэлтэс, дүүргийн Засаг даргын Тамгын газар, харьяа байгууллага, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгжүүдээс гаргуулан авч, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах

- Монгол улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн “Үйлдвэржилтийг эрчимжүүлэх талаар Засгийн газарт чиглэл өгөх тухай” 09 дүгээр зарлиг, Монгол улсын Засгийн газрын 2011 оны 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллах талаарх 2015 оны 02-01/1278 тоот албан бичгийг Нийслэлийн төр захиргааны бүх байгууллагуудад хүргүүлж ажиллаж байна. Дотоодын үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж ажиллахыг уриалга болгон Жижиг, дунд, өрхийн үйлдвэр эрхлэгчдийг аж ахуйн ур чадвар эзэмшүүлэх, чадавхижуулах анхны сургалтыг Best Shoes гутлын үйлдвэр дээр 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулж явууллаа.

10. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд бизнес инкубацийн үйлчилгээг үзүүлэх, тэдгээрийг бойжуулах, хөнгөлөлттэй зээлд хамруулах ажлыг нийслэлийн холбогдох нэгжүүдээр дамжуулан гүйцэтгүүлэх

- Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зөвлөлийн хурлын шийдвэрээр 2015 онд нийт 55 төсөлд 5 тэрбум 603.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосоны үр дүнд шинээр ажлын байр-2, ажлын байраа шинэчилсэн– 8, шинээр бий болсон орон тоо – 65, тоног төхөөрөмжийн шинэчлэлт – 82, түүхий эд материал татсан-14, шинээр бий болсон бүтээгдэхүүний нэр төрлийн тоо - 4 байна. Тайлант онд Нийслэлийн 9 дүүргийн жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвөөр дамжуулан 478 үйлдвэр эрхлэгчдэд шаардагдах зөвлөгөө, мэдээллийн хүргэж ажиллалаа. Мөн 20 удаагийн сургалтыг 3 модулиар зохион байгуулж, нийт 848 үйлдвэр эрхлэгчдийг Төсөл бичих сургалтанд хамруулсан байна.
- Нийслэлийн төсвийн 2015 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 1.0 тэрбум төгрөг тусгагдсан. Энэхүү ажлын хүрээнд Улсын зээлийн батлан даалтын сантай хамтран ажиллах талаарх саналыг 2А/326 тоот албан бичгээр Зээлийн батлан даалтын сангийн Удирдах зөвлөлд хүргүүлэн, хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулаад байна. Гэвч Зээлийн батлан даалтын сангаас 2015 оны 06 дугаар 05-ны өдрийн 1/24 тоот албан бичгээр Удирдах зөвлөл болон Зээлийн батлан даалтын хорооны бүрэлдэхүүнд нийслэлээс гишүүн оруулах боломжгүй талаарх хариуг ирүүлсэн байгаа. Иймд нийслэлийн зүгээс зээлийн батлан даалтад зарцуулагдах 1.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг төсвийн тодотголоор дахин хэлэлцэж, эх үүсвэрийг татсан байгаа.
- Аж үйлдвэрийн сайд, Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 01 дүгээр сарын 22-ны өдрийн хамтарсан тушаал, захирамжаар “Монголд үйлдвэрлэв, Цагаан сар-2015” үзэсгэлэн худалдааг 01 дүгээр сарын 28-ны өдрөөс 02 дугаар сарын 04-ний өдрүүдэд 9 дэх жилдээ зохион байгууллаа. Үндэсний үйлдвэрлэлийг сурталчлах, дэмжих, импортын бүтээгдэхүүний хэрэглээг багасгах “Үндэсний Үйлдвэрлэлээ дэмжицгээе” уриан дор 80 гаруй аж ахуйн нэгж, үйлдвэр эрхлэгчид оролцож, нийтдээ 3 тэрбум орчим төгрөгийн борлуулалт хийгдсэн. Мөн нийслэлийн 6 дүүрэг, байнгын ажиллагаатай “Монголд үйлдвэрлэв” худалдааны 2 төвөөр дамжуулан нийт 800 гаруй аж ахуйн нэгж болон өрхийн үйлдвэрлэгч, бичил бизнес эрхлэгчид оролцсон.
- Аж үйлдвэрийн яам, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран 2015 оны 06 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд Мишээл экспо төвд Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологи - 2015” олон улсын үзэсгэлэн яармагийг амжилттай зохион байгууллаа. Үзэсгэлэнд Монгол, БНХАУ, Польш, БНЧУ, ӨМӨЗО, БНАСУ, Тайван улсын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй нийт 110 гаруй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид оролцсон бөгөөд "Аз хур" ХХК Дэлхийн жүжгийн дээжис 11 боть номоороо Гран при шагналыг хүртлээ. Сонгинохайрхан дүүргийн Худалдаа үйлчилгээний хэлтэстэй хамтран “Сонгинохайрхан дүүргийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчдийн зөвлөлгөөн”-ийг зохион байгуулан, зөвлөлгөөнд “Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний талаар НҮХААГазрын дарга мэдээлэл хийлээ.

11. Малын үүлдэр угсааг сайжруулж ашиг шимийг нэмэгдүүлэхэд биотехнологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх ажлыг төрийн захиргааны төв болон салбарын шинжлэх ухааны байгууллагуудтай хамтран зохион байгуулах

- “Үржлийн шилмэл сүрэг” хоршоо, “Тайшир өргөө” ХХК-тай хамтран Норвегийн улаан үхрийн үрийн зохиомол хээлтүүлгээр гарган авсан анхны төлөө хүлээн авч, Монголд

анх удаа “Тугалын баяр”-ыг тэмдэглэсэн. Норвеги улсын “ЖИНО” компанитай мал аж ахуйн салбарт хамтран ажилласнаар шинжлэх ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлж, мал үржлийн ажилд ахиц гарган, өндөр ашиг шимтэй Норвегийн улаан үхрийг нутагшуулах, малын үүлдэр, угсаа сайжирч, мал аж ахуйн бүтээмжийг нэмэгдүүлэх, цаашид Норвеги улстай хамтран ажиллах “Санамж бичиг”-ийг байгуулахаар төлөвлөн, энэхүү санамж бичгийн хүрээнд мал аж ахуйн салбарт хамтран ажиллаж, малын үржлийн ажилд шинэ технологийг нутагшуулах, Норвегийн улаан үхрийн үрийг хөнгөлттэй үнээр Монголд нийлүүлэх, өндөр ашиг шимтэй шинэ төрлийн үрийг нийлүүлэн, нутагшуулах зэрэг ажлуудыг гүйцэтгэхээр тусгаж ажиллалаа.

- Малын нөхөн үржихүйн талаарх мэдээ, мэдээллийг байгууллагын веб сайтад байршууллаа. Энэ чиглэлээр МУСҮТ, МЭҮГ, НМХГ-тай хамтран ажиллалаа. Мөн Баянзүрх дүүргийн “Жижиг зээрд”, “МЭГ”, Хан-Уул дүүргийн “Ганган-Буга”, “Гүн тэрэм”, Сонгинохайрхан дүүргийн “Буянт-Хөхий” мал эмнэлэг, үржил үйлчилгээний нэгжүүдтэй хамтран нийт 75 өсвөр хээлтэгч, 25 буханд ангилалт хийж баталгаажуулсан.
- Сүүний үхрийн аж ахуй эрхлэгч, иргэдийн захиалгыг авч, үржүүлгийн техникчидтэй хамтран ажиллаж, 10 аж ахуй нэгж, 60 өрхийн 135 гаруй үнээнд зохиомол хээлтүүлэг хийгдлээ. Уг ажлын хүрээнд Малын удмын сангийн үндэсний төв, “Үржлийн шилмэл сүрэг” хоршоотой хамтран фермүүдийн зохиомол хээлтүүлэг хийсэн үнээний хээл авалтыг шалгах ажлыг зохион байгуулж, нийслэлийн хэмжээнд үнээний хээл авалт 85 хувьтай байна. Мөн Малын удмын сангийн үндэсний төвөөс зохион байгуулсан “Бод малын зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх сургалт”-нд нийслэлээс 3 мэргэжилтэнг хамруулж ажиллалаа.

12. Мал, тэжээвэр амьтны тэжээлийн үйлдвэрлэл эрхлэхийг бүх талаар дэмжиж ажиллах

- “Тэжээл” дэд хөтөлбөрийн төслийг 8 бүлэгтэйгээр боловсруулж, НИТХТ-ийн 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 232 дугаар тогтоолоор батлууллаа.

13. Мал сүргийг индексжүүлж, им, тамгажуулах ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах

- Пост, захуудын байршлыг тогтоож, сүлжээний программд холбох нөхцлийг судлан, шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгаа, тооцоог гаргаж, нэгдсэн сүлжээнд холбоход шаардлагатай төсвийн саналыг тусган холбогдох газарт хүргүүлсэн.
- Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан NLIS программд 10000 бог малын мэдээллийг оруулж, төлөвлөгөөний биелэлтийг бүрэн хангаж ажиллалаа. Малын үндэсний бүртгэл мэдээллийн систем хяналтын онлайн программд 2015 оны мал төллөлтийн мэдээ болон нийслэлийн 22 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн мэдээллийг оруулж, баяжилт хийсэн. Мөн малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан NLIS программаас Малын үндэсний бүртгэл мэдээллийн систем хяналтын онлайн программ руу 39.412 малын бүртгэл, малын эзний мэдээллийг хөрвүүлж оруулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн мал бүхий 6 дүүргийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд арьс ширний программын сургалтыг зохион байгууллаа.

14. Усалгаатай газар тариаланг өргөжүүлэх ажиллагааг эрчимжүүлэх, хамгаалагдсан хөрсний /хучлагатай талбай, хүлэмж/ болон төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх

- Нийслэлийн засаг даргын 2015 оны 4 дүгээр сарын 15 өдрийн А/293 дугаар захирамжын дагуу Нийслэл хот орчимд малын бэлчээрийн усан хангамжийг

сайжруулах зориулалтаар 10 ширхэг инженерийн хийцтэй худаг гаргах ажлыг зохион байгуулж гүйцэтгэчийг шалгаруулж, худгийг хүлээн авлаа.

- Өрх бүр хэрэгцээт төмс, хүнсний ногоогоо өөрсдөө тариалж, арчилж, хураах, хадгалах, овчин хортонтой тэмцэх технологийн сургалтуудыг холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттайгаар зохион байгууллаа. 2015 онд нийт 16 сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 1000 гаруй иргэдийг хамруулсан байна.
- Нийслэлийн хэмжээнд эрүүл, чанартай хүнсний хэрэглээг дэмжих, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2009 оны 208, 2010 оны 290 дугаар захирамжуудаар батлагдсан Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо Баян-Уулын амны 100.0 га, Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Таширын хөндийн 300.0 га газрыг гэрээгээр ашиглагчдын газрын төлбөр болон ашиглалтанд хяналт тавьж Таширын амны 300.0 га-гаас 55 иргэн, аж ахуйн нэгжийн 167.0 га, Баян-Уулын 100.0 га-гаас 28 иргэн аж ахуйн нэгжийн 48.0 га талбайг эрх шилжүүлэх саналыг ЗАА-нд хүргүүлсэн. Эрх шилжүүлэх асуудал Засгийн газрын 2013 оны 38 дугаар тогтоолын дагуу шийдвэрлэгдэхээр хүлээгдэж байгаа болно.
- 2015 оны байдлаар 10,8 га талбай өвлийн хүлэмж, 18,6 га талбай зуны хүлэмжинд тариалалт хийгдэж 2,9 тн хүнсний ногоо хураан авч байна. Хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэл нэмэгдснээр хэрэглэгчдийн хүнсэнд хэрэглэх ногооны нэр төрөл нэмэгдэх, шинэ ургацын хүнсний ногоо хэрэглэх хугацаа уртсах, чанар сайжрах зэрэг үр дүнгүүд гарч байна.

15. Өрх бүрийг хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах хөдөлгөөнд хамруулж, өрхийн тариаланг дэмжих зорилгоор төмс, хүнсний ногооны үр, үрслэг, жимсний суулгац, тарьцыг хөнгөлөлттэй үнэ болон зээлээр нийлүүлэх, суулгац үйлдвэрлэх санаачилгыг дэмжин туслах

- ХХААЯамны Төрийн нарийн бичгийн даргын А-173 дугаар тушаалын дагуу хүнсний ногооны тариалалт, өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор улсын төсвөөс 5-7 нэр төрлийн 2015,8 кг хүнсний ногооны үрийг олгосныг нийслэлийн 9 дүүргээр дамжуулан 1500 иргэн аж ахуйн нэгжид, НҮХААГ-т ирсэн өргөдөл хүсэлтийн дагуу 170 иргэн, аж ахуйн нэгж, бүлэг хоршоодод олгож гарын авлагын хамт тараалаа.
- “Чацаргана” үндэсний хөтөлбөрийн хүрээнд жил бүр зарлагддаг “Чацарганы суулгац зээлээр олгох” төсөлд 2015 оны хавар 5 аж ахуйн нэгж, 14 иргэн шалгарч 25,900 ширхэг 2 настай “Чуйская” сортын чацарганы суулгацыг олгож 21 га талбайд тариалууллаа. Тариалалтын байдалд зөвлөгөө өгч ажиллалаа. Мөн 2012 онд “Хархорин” ХХК-наас суулгац авч тариалалт хийсэн Налайх дүүргийн 5-р хорооны иргэн Н.Ганбатад 400, 2013 онд Баянзүрх дүүргийн иргэн Д.Нацагдоржид авсан 500, Хаан жимс “Эс-Би-Ти” ХХК-наас суулгац авсан “Вундербург” ХХК-нд 600 ширхэг суулгацыг тус тус нөхөн олголтоор өгч тариалалтыг хийлгүүлээ.
- “Чацаргана” үндэсний хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагддаг “Чацаргана, бусад жимс жимсгэнэ тариалах” сургалтыг 03 дугаар сарын 16-17-нд Багануур, 18-19-нд Хан-Уул, 23-24-нд Сонгинохайрхан, 04 дүгээр сарын 22-нд Баянзүрх дүүргийн ЗДТГазар, МЧТҮҮХолбоотой хамтран танхимын болон талбайн хэлбэрээр зохион байгуулан 265 гаруй иргэн, аж ахуйн нэгж нийгмийн төлөөллийг хамруулан оролцуулсан. Сургалтанд оролцогчдод гарын авлага, ном зөвлөмжийг тарааж, зөвлөгөө өгч ажилласан.
- Солонгос – Монголын бизнес төв, ХААИС-тай хамтран 2015.03.27–29 өдрүүдэд “2015 Сол.Мон газар тариалангийн тоног төхөөрөмж, хангамж материал, хотын үйлдвэрлэл хөдөө аж ахуйн үзэсгэлэн” яармагыг зохион байгууллаа. Тус үзэсгэлэн нь Монголын хөдөө аж ахуйн салбарыг эрчимжүүлэх зорилгоор газар тариалан, мал аж ахуй эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд БНСУ-ын газар тариалангийн тоног төхөөрөмж

үйлдвэрлэгч 20 гаруй аж ахуйн нэгж, компаниуд үйлдвэрлэсэн тоног төхөөрөмжөө танилцууллаа.

- Нийслэлийн хэмжээнд эрүүл, чанартай хүнсний хэрэглээг дэмжих, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2009 оны 208, 2010 оны 290 дугаар захирамжуудаар батлагдсан Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо Баян-Уулын амны 100.0 га, Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Таширын хөндийн 300.0 га газрыг гэрээгээр ашиглагчдын газрын төлбөр болон ашиглалтанд хяналт тавьж Таширын амны 300.0 га-гаас 55 иргэн, аж ахуйн нэгжийн 167.0 га, Баян-Уулын 100.0 га-гаас 28 иргэн аж ахуйн нэгжийн 48.0 га талбайг эрх шилжүүлэх саналыг ЗАА-нд хүргүүлсэн. Эрх шилжүүлэх асуудал Засгийн газрын 2013 оны 38 дугаар тогтоолын дагуу шийдвэрлэгдэхээр хүлээгдэж байгаа болно.

16. Байгаль орчин, бүтээгдэхүүний чанарт сөрөг нөлөөгүй аргаар тариалангийн хог ургамал, өвчин, хортон шавьж, мэрэгчидтэй тэмцэх арга ажиллагааг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах

- “Хүнсний ногооны ургамал хамгаалал” сэдэвт сургалтыг 06 дугаар сарын 4,5-ны өдрүүдэд ХААИСургууль дээр нийслэлийн 9 дүүргийн газар тариалан эрхэлдэг аж ахуй нэгжийн төлөөлөл болон ногоо тарих сонирхолтой нийт 30 гаруй иргэдийг хамруулсан сургалт зохион байгуулж, ногоо тарих арчлах, хамгаалах, хураах технологи зааж, авлага болон ногооны үр олгосон.
- 2015 оны 6 сарын 24-30-ны өдрүүдэд дүүргүүдийн ЗДТГ-тай хамтран ургацын явцын байдалтай танилцлаа. Энэ жилийн хувьд гандуу хуурай байсан учир ил талбайд тариалсан ногооны ургалтын байдал тааруу, хүлэмжний ногооны сайн, эрт ургацын ногоо гарч эхэлсэн байлаа. Гандуу байгаагаас шалтгаалан өвчин хортон, хөнөөлт шавьж ихтэй байгаа учир буглаа цох, хачиг гэх мэт хортонгууд бусад жилүүдээс их гарсан байсан. Эдгээртэй тэмцэх талаар хэлтэсээс зохион байгуулсан сургалтуудын үеэр Ургамал хамгааллын хүрээлэнгийн мэргэжилтнүүдийг урьж хичээл заалган иргэдэд мэдээлэл өглөө. Мөн газар тариалан эрхлэж буй иргэдийн талбайгаар явж ургамал хамгааллын бодисын зүй зохистой хэрэглээний талаар зааварчилгаа өгч ажиллалаа.

Тав. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

5.1. Үйл ажиллагааны ил тод байдал

Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай НЗД-ын 2012 оны 606 дугаар захирамжийн дагуу байгууллагын цахим хуудсанд дараах мэдээллүүдийг байршууллаа. Үүнд:

- Мэдээ мэдээлэл
- Газрын даргын тушаал
- Хүний нөөц
- Төсөв санхүү
- Тайлан, төлөвлөгөө
- Төсөл хөтөлбөр
- Худалдан авалт
- Өргөдөл гомдлын шийдвэрлэлт
- Хууль, эрх зүй
- Шилэн данс

- Төрийн үйлчилгээ гэх мэт мэдээллийг тухай бүр тогтмол баяжуулж, цахим хуудасны хэвийн үйл ажиллагааг хангах ажиллаж байна.

“Ухаалаг Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор байгууллагаас иргэд, хуулийн этгээдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд “UBLEGAL.MN” цахим хуудсанд 2015 онд байгууллагаас гарсан 68 захирамжлын баримт бичгийг холбогдох журмын дагуу тухай бүр орууллаа.

5.2 Хүний нөөцийн ил тод байдал

- Байгууллагын албан хаагчдад хийх сургалт, арга зүйн ажлын төлөвлөгөөг гарган, эхний хагас жилийн байдлаар мэргэжил, арга зүйн 16 удаагийн сургалтанд нийт 21 мэргэжилтэн, гадаадын сургалтанд 10 мэргэжилтэн, мэргэжлийн дипломын сургалтанд 15 мэргэжилтэнг тус тус суралцах боломжийг хангаж ажиллалаа.
- 2014 оны ҮДГ-ээр хангалттай сайн үнэлэгдсэн 11 албан хаагчдын 2015 оны цалингийн шатлалыг 2015.01.20-ны А/01 дүгээр тушаалаар нэмсэн.
- Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/181 дугаар захирамжийг үндэслэн 2015 оны 04 сарын 01-ний өдрөөс эхлэн 4 албан хаагчдад зэрэг дэвийн нэмэгдлийг олгож байна.
- Хаан банктай гэрээг шинэчлэн байгуулж, гэрээний нөхцөлд цалингийн зээлийг хамтран эзэмшигч шаардахгүйгээр олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлж, цалингийн зээлийн ерөнхий нөхцлийн сайжруулах саналыг хүргүүлж, шийдвэрлэсэн.
- Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-д орсон өөрчлөлт болон Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн 2014 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг 2015.01.22-ны өдрийн байгууллагын хурлаар нийт албан хаагчдад танилцуулж, байгууллагын вэб сайтад байршуулсан.
- Дотоод мессенжерийн outlook програмыг нэвтрүүлж албан хаагчид мэдээллээ түргэн шуурхай илгээх, хүлээн авах, харилцах боломжийг бүрдүүллээ.
- Нийслэлийн Тамгын газраас нэвтрүүлж байгаа цахим ажлын байр и-оффис дотоод удирдлагын програмыг нэвтрүүлж бүх албан хаагчдын мэдээллийг оруулж, нэвтрэх эрх үүсгэн ашиглах зааврыг танилцууллаа.
- Нийслэлийн Засаг даргын 2014 оны 12 сарын 24-ний өдрийн А/1063 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн хөрөнгө оруулалтаар худалдаж авсан орон сууцнаас нийслэлийн төрийн албан хаагчдад худалдах журмыг нийт албан хаагчдад танилцуулсан.
- НҮХААГ-ын УБ-орон сууц сангаас албан хаагчдад орон сууцны урьдчилгаа төлбөрийн дэмжлэг үзүүлэхэд баримтлах журмыг батлан, шалгаруулалт явуулж, болзлыг хангасан 3 мэргэжилтэнд орон сууцны урьдчилгаа төлбөрийн дэмжлэг үзүүлэхээр болсон. Мөн банкны зээлд хамрагдахад нь дэмжлэг үзүүлж давхардсан тоогоор 25 албан хаагчдад байгууллагын тодорхойлолт гаргаж өгсөн.
- Байгууллагын дотоод журам, ТАТХ-ийн дагуу албан хаагчдад болон ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан өндөр настанд буцалтгүй тусламжинд нийт 5,681,684 төгрөг зарцууллаа.
- Төрийн захиргааны албан тушаал эрхэлж байгаа Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын албан хаагчид өөрийн үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн зарчим, албан үүргээ гүйцэтгэхдээ удирдлага болгох ёс зүйг эрхэмлэн дээдлэх зүйлс, дагаж мөрдөх НҮХААГ-ын дагаж мөрдөх ёс зүйн дүрмийг батлуулсан.
- Байгууллагын албан хаагчдын зан төлөвийн судалгааг авах ажлыг зохион байгуулж, үр дүнгийн шагнал урамшуулал олгоход харгалзан дүгнэсэн. “Имасо” сургалт үйлчилгээний институттай хамтран “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр сургалт явууллаа.

- УИХ-ын 5 дугаар тогтоолд орсон өөрчлөлтийн дагуу 2014 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг нийт 9 албан хаагчаар цахим болон цаасан суурьтайгаар гаргуулан авч, хуулийн хугацаанд АТГ-т хүргүүлсэн.
- Албан тушаалтны ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдлийг үнэлгээний хороонд ажилласан албан тушаалтнуудаас гаргуулан авсан.
- Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2015 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан ажлуудаас өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон хэрэгжүүлэх ажлуудын төлөвлөгөөг гаргаж, биелэлтийг гарган, НЗДТГ-т хүргүүлэв.
- Хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөний программд албан хаагчдын мэдээллийг оруулж, тайланг Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлээ.
- Байгууллагын 2015 оны орон тоо, хөдөлгөөний мэдээг 1-р улирлын байдлаар НЗДТГ-ын НЗУХ-т, 2-р улирлын байдлаар Нийслэлийн Хөдөлмөрийн газарт, Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт, бүрэлдэхүүн хөдөлгөөний 2015 оны тайлан гаргаж, Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлэв.

Зургаа. Хэрэглэгчийн үнэлгээ

2015 онд үндсэн ажил үйлчилгээний чиг хандлагыг тусгасан 4 асуулт бүхий хуудсыг шинэчлэн боловсруулж, үйлчлүүлэгч иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас нийт 265 санал ирүүлсэн байна.

Ирүүлсэн саналуудын 27 хувь нь үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх, 25 хувь нь ХАА-н сургалт авах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн бол 17хувь нь мэдээллийг хүртээмжтэй, түргэн шуурхай авах, төсөв хөтөлбөрт хамрагдах, 29 хувь нь техник тоног төхөөрөмж хөнгөлөлттэй үнээр авах, 6 хувь нь нарийн ногооны үр авах саналтай байна.

Байгууллагын цахим хуудсыг шинэчлэн ажиллуулж эхэлснээс хойш нийт 169901 хүн зочилж байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг авсан байна. Нийт 116 хүн байгууллагын үйл ажиллагааны талаар санал өгсөнөөс 53% маш сайн, 25% нь хангалттай, 22% хангалтгүй үнэлгээг өгсөн байна.

Долоо. Цаг үеийн ажлын онцлогтой холбогдох бусад мэдээлэл

Нийслэлийн ХАА-н салбарын дотоод нөөц, боломж бодит байдлаа үнэлж, шинэ агротехнологи болон бусдын амьдралаас суралцах замаар иргэд, аж ахуй нэгжүүдийг чадавхжуулах, арга туршлага солилцох уулзалт- зөвлөгөөнийг Монголын баг сумдын холбоо, Шинэ тосгон хөдөлгөөн зэрэг ТББ-уудтай хамтран 2015 оны 04-р сарын 22-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Уг уулзалт зөвлөгөөнд НҮХААГ-ын дарга Г.Пүрэвсүрэн “НҮХААГ-аас явуулж буй бодлого, үйл ажиллагаа” илтгэлийг тавьж, оролцогчдын асуултанд хариулт өглөө.

Уулзалт зөвлөгөөнд БНСУ-ын Хөдөлмөрийн баатар “Шинэ тосгон” хөдөлгөөнийг үүсгэн байгуулагч Ха Са Юн урилгаар оролцлоо. Ха Са Юн өөрийнхөө туулж өнгөрүүлсэн амьдрал, олон жилийн уйгагүй хөдөлмөрийн ачаар газар тариаланг эрхэлж, амжилтанд хүрсэн арга туршлагаа хуваалцаж, санаачилж хэрэгжүүлсэн технологио танилцууллаа. Түүнчлэн Иргэдийн хөдөлмөрч, санаачилгыг төрөөс бодлогоор дэмжснээр тухайн орны хөгжилд хэрхэн нөлөөлдөг болохыг шинэ тосгон хөдөлгөөний түүхээс сэдэвлэн ярьсан ба монгол орны газар тариалангийн онцлог, хэрхэн ажиллаж амьдрах боломж байгааг олж харснаа танилцуулсан нь оролцогчдын сонирхлыг ихээхэн татлаа. Уулзалтын үеэр оролцогчдод гарын авлага, номыг тараалаа.

“Бүтээн байгуулалтын дээд шагнал - 2015” шалгаруулалтын Дэвшилтэт техник, технологи бүхий шинэ үйлдвэрийн бүтээн байгуулалт номинацид шалгарсан “Бест шүүз” ХХК-ийн үйл ажиллагаатай танилцах аялалыг 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулсан. Энэхүү ажлын хүрээнд нийслэлийн төвийн 6 дүүргийн гутлын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг “Хүүгийн гутал” ХХК, “Баянцагаан нуур” ХХК, “Индра шүүз” ХХК зэрэг 15 аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн төлөөллийг үйлдвэрийн үйл ажиллагаа, шинэ техник технологитой танилцуулж, цаашид хамтран ажиллах талаар санал бодлоо солилцлоо.

Тус компани нь 2001 онд гутал, цүнх, арьсан эдлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл худалдааны чиглэлээр байгуулагдан 15 дахь жилдээ үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байгаа бөгөөд Монгол улсын зах зээлд гоёлын болон өдөр тутмын гутлыг чанарын өндөр түвшинд үйлдвэрлэж байгаа дотоодын цөөхөн компанийн нэг юм.

ТАНИЛЦСАН:

ҮЙЛДВЭР ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА

Г.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

Д.МЯГМАРСҮРЭН

НЭГТГЭСЭН:

ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Р.УНДАРМАА

**НИЙСЛЭЛИЙН ҮЙЛДВЭР,
ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**